

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

I.Нийтлэг звйл

1.Монгол Улсын Үндсэн хууль нь Монгол Улсын ард иргэд, нийгмийн бvх хэсэг бvлгийн нийтлэг ашиг сонирхлын цогцолсон илэрхийлэл мон.

2.Монгол Улсын vндэсний аюулгvй байдал /цаашид "vндэсний аюулгvй байдал" гэх/ гэж Монгол Улсын vндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нохцол баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ. Үндэсний аюулгvй байдлыг хангах бодлогын vзэл бодлын vндэс нь эх оронч vндэсний vзэл байна.

3.Монгол Улсын vндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард тvмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бvрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бvрэн бvтэн байдал, улсын хилийн халдашгvй дархан байдал, эдийн засгийн харьцангуй бие даасан байдал, экологийн тэнцвэрт хогжил, vндэсний эв нэгдэл багтана. Монгол Улсын vндэсний язгуур ашиг сонирхол нь тор, ард тvмний онцгой анхаарал хамгаалалтад байна.

4.Үндэсний аюулгvй байдлыг хангах гэж Монгол Улсын vндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалан бэхжvвлж тал бvрийн баталгаа буй болгоход чиглэсэн торийн бодлого, тор, тvвний байгууллага, албан тушаалтнаас авч буй, иргэдээс хэрэгжvвлж буй арга хэмжээг хэлнэ. Эдгээр арга хэмжээ нь урьдчилан сэргийлэх, бvтээн байгуулах чиг хандлагатай байна. Монгол Улс нь эдийн засаг, соёл, шинжлэх ухаан-технологи, боловсрол зэрэг салбарт олон улсын хэмжээнд орсолдох чадвартай байхыг чухалчилна.

Нэг.Үндэсний аюулгvй байдлын бvтэц

5.Үндэсний аюулгvй байдал нь дараах vндсэн хэсгээс бvрдэнэ:

- 1/ Монгол Улсын оршин тогтнохын аюулгвй байдал;
- 2/ нийгэм-торийн байгууллын аюулгвй байдал;
- 3/ иргэдийн эрх, эрх чолооний аюулгвй байдал;
- 4/ эдийн засгийн аюулгвй байдал,
- 5/ шинжлэх ухаан, технологийн аюулгвй байдал;
- 6/ мэдээллийн аюулгвй байдал,
- 7/ монгол соёл иргэншлийн аюулгвй байдал;
- 8/ хvн ам, удмын сангийн аюулгвй байдал;
- 9/ экологийн аюулгвй байдал.

Хоёр. Үндэсний аюулгвй байдалд нөлөөлөх хvчин звйлvвд

6. Үндэсний аюулгвй байдалд нолоолох хvчин звйлийг эх сурвалжаар нь дотоод, гадаад, цаг хугацааны хувьд гэнэтийн, тодорхой хугацааны, тvvхэн нэгэн veийн, монхийн гэж тус тус ангилна. Монгол Улсын vндэсний язгуур ашиг сонирхол нь монхийн ангиллын ашиг сонирхол мон.

7. Үндэсний аюулгвй байдалд сорог нолоолж болох хvчин звйлийг шинж чанарын vвднээс объектив, субъектив; учруулах аюулын магадлалаар нь бодит болон болзошгвй гэж тус тус ангилна. Үндэсний аюулгвй байдлыг хангах, бэхжvвлэх бодлого нь аливаа аюулыг "болзошгвй" вeд нь тодруулан тогтоож арилгах, субъектив аюулыг цаг тухайд нь арилгах замаар объектив аюулыг багасгах, урьдчилан сэргийлэхэд чиглэнэ.

8. Үндэсний аюулгвй байдалд нолоолох гадаад хvчин звйл:

Монгол Улсын vндэсний аюулгвй байдал нь олон улсын аюулгвй байдлын бvрэлдэхvн хэсэг мон богоод тvvнээс шууд хамаарна. Улс торийн орон зайн хувьд аюулгвй байдлыг дэлхийн, бvс нутгийн, салбар бvс нутгийн гэж ангилна.

9. Үндэсний аюулгвй байдалд нолоолох дотоод хvчин звйл:

Үндэсний аюулгвй байдлыг дотоод орон зайгаар нь улсын, бvсийн, аймаг, нийслэлийн, сум-нутгийн гэж ангилна.

Гурав.Үндэсний аюулгвй байдлыг хангах арга зам, баталгаа

10.Үндэсний аюулгвй байдлыг нийгэм, улс тор, зохион байгуулалт, эдийн засаг, дипломат, цэрэг, тагнуул, хууль зvйн аргаар дангаар буюу олон улсын хамтын ажиллагааг хогжvвлэх замаар хангана.

11.Үндэсний аюулгвй байдлыг хангах vндсэн арга хэрэгсэл нь баттай мэдээлэл, нарийн судалгаа, тооцооны vндсэн дээр vйл явдлын орнолт, хогжлийг урьдаас харж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах явдал мон.

12.Үндэсний аюулгвй байдлын vндсэн баталгаа нь монголын ард тvмэн оороо, Монгол Улсын тор мон.

13.Үндэсний аюулгвй байдлын олон улсын баталгаа нь улс тор, хууль зvй, ёс суртахуун-сэтгэл зvйн баталгаанаас бvрдэнэ. Олон улсын баталгааг дангаар, хоёр болон олон талын арга хэмжээг хослуулан авах замаар буй болгож бэхжvвлнэ. Цэрэг-улс торийн аюулгвй байдлын баталгааг хамтын хvчээр аюулгвй байдлыг хангах тогтолцоо бvрдvвлэх, оролцох замаар хангана.

Дөрөв.Үндэсний аюулгвй байдлыг хангах тогтолцоо

14.Үндэсний аюулгвй байдлыг хангах vвргийг Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлогч, тvвний тэргvвлсэн Үндэсний аюулгвй байдлын зовлол, Засгийн газар, хууль сахиулах болон торийн захиргааны тов, орон нутгийн байгууллагууд гvйцэтгэнэ.

15.Хууль тогтоох, гvйцэтгэх, шvvx эрх мэдлийг хэрэгжvвлэгч байгууллагууд, нутгийн оороо удирдах байгууллагууд нь энэхvв vзэл баримтлалын vзэл санааг Монгол Улсын

Үндсэн хууль, хууль тогтоомж болон эрх зүйн бусад холбогдох актаар бэхжүүлж, тус тусын эрх хэмжээний дотор хэрэгжүүлэх үүрэгтэй.

16. Улс тор, олон нийтийн байгууллагууд болон иргэд Үндэсний аюулгүй байдлыг хангах тухай хууль тогтоомж, энэхүү үзэл баримтлалыг чанд мордлог болгож, тэдгээрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцоно.

17. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зовлол тухайн үеийн байдлыг харгалзан энэхүү үзэл баримтлалыг хэрэгжүүлэх стратеги, тактикийг уялдуулан зохицуулах үүргийг хвлээх богоод үндэсний аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаад хяналт тавьж, Улсын Их Хуралд жил бүр мэдээлж байна.

18. Үзэл баримтлалыг хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн байгууллагууд оорсдийн тосовт тусгаж гүйцэтгэнэ. Тусгай арга хэмжээ авах нохцолд зардлыг улсын тосвоос санхүүжүүлнэ.

Тав. Үндэсний аюулгүй байдлын мэдээллийн сан

19. Үндэсний аюулгүй байдлыг хангах торийн бодлогыг уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэхэд шаардагдах бүх торлийн мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллага, иргэд, гадаадын эх сурвалжаас олж авах богоод, мэдээллийн нэгдсэн санг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зовлолийн дэргэд байгуулна.

Сүүлд шинэчлэгдсэн (Friday, 2007 оны 07 сарын 27)